



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/485

Хэрлэн сум


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дах заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Ахмадын хорооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан “Манлайлагч ахмадууд” чуулга уулзалт хүндэтгэлийн арга хэмжээ, “Ахмадын урлагийн 3 дугаар наадам”-ыг Чингис хотод 2023 оны 9 дүгээр сарын 28-ны 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдрүүдэд зохион байгуулах зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ